БАТЛАВ БҮЖГИЙН УРЛАГИЙН
ЗАХИРАЛ Ч.БАТ-ЭРДЭНЭ

СОЁЛ УРЛАГИЙН ... УРЛАГИЙН СУРГУУЛЬ УКД0053 УЛААНБААТАР ХОТ

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2017 оны 11 дугаар сарын 09-ны өдөр №.20 Улаанбаатар хот

Нэг талаас Бүжгийн урлагийн сургууль /цаашид "Захиалагч" гэх/, түүнийг төлөөлж , С.Далай нөгөө талаас /цаашид "Гүйцэтгэгч" гэх/, Эрэмгий жалаар ХХК-ны захирал Ц.Мөнхбаатар нар /цаашид хамтад нь "Талууд" гэх/ дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хичээлийн байрны 4-р заалны урсгал засвар, хувцас солих өрөөний 4 хаалт хийх, 315,314,301,303 өрөөний хананд дуу тусгаарлагч хийх урсгал засварын ажил /цаашид "ажил" гэх/-г гүйцэтгэгчээр гүйцэтгүүлнэ.

1.2. Гүйцэтгэгч нь урсгал засварыг 2017 оны 11 дүгээр сарын 13-20-ны өдөр чанарын шаардлага хангахаар өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ.

### Хоёр. Талуудын эрх, үүрэг

***2.1. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг:***

2.1.1. Төлбөрийг тохиролцсон хугацаанд төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

2.1.2.Урсгал засварын ажлын төсвийн дагуу чанарын болон мэргэжлийн өндөр түвшинд , иж бүрэн, хугацаанд нь хийж гүйцэтгэн гүйцэтгэгч байгууллагад хүлээлгэн өгнө.

2.1.3. Гүйцэтгэгч нь тухайн хугацаанд засварлах баталгаа гарган ажлыг хариуцах үүрэгтэй.

2.1.4. Ажлын гүйцэтгэлийн явцыг захиалагчид тогтмол мэдээлэх үүрэгтэй.

***2.2. Захиалагчийн эрх, үүрэг:***

2.2.1. Энэхүү гэрээнд заасны дагуу төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэгтэй.

2.2.2. Тогтоосон хугацаанд уг ажлыг бүрэн хийлгүүлж хүлээн авна.

2.2.3. Захиалагч нь ажлын гүйцэтгэлийг хянаж, батална.

2.2.4. Ажлын гүйцэтгэлийн явцтай танилцах, ажлыг гэрээнд заасан хугацааны дотор мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд гүйцэтгэхэд хяналт тавих, шаардлага гаргах, санал оруулах эрхтэй. Хэрэв ажлын үр дүн гэрээнд заасан шаардлагыг хангаагүй, дутуу хийж гүйцэтгэсэн бол гэрээгээр тохиролцсон ажлын үнэ, хөлсийг зохих хэмжээгээр бууруулах эрхтэй.

2.2.5. Гүйцэтгэгч нь гэрээнд заасан хугацаанд ажлыг бүрэн гүйцэтгээгүй буюу дутуу хийсэн нөхцөлд захиалагч өөрийн санаачилгаар гэрээг цуцлаж, өөрт учирсан хохирлоо гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх эрхтэй.

### Гурав. Төлбөрийн хэмжээ, төлөх хуваарь

3.1 Захиалагчийн гүйцэтгэгчид төлөх 8,300,000 төгрөг/Найман сая гурван зуун мянга/-ийн засварын ажлын санхүүжилтийн 80%-ийн урьдчилгааг Хас банк 5002246867 тоот дансанд шилжүүлнэ.

3.2. Гэрээт засварын ажлыг гүйцэтгэсний дараа гүйцэтгэгч талын нэхэмжлэхийг үндэслэн засварын ажлын санхүүжилтийн үлдэгдэл 20%-ийг олгоно.

### Дөрөв. Гэрээг цуцлах үндэслэл, хариуцлага

4.1. Талууд энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс болж нөгөө талдаа учруусан хохирлыг барагдуулах үүрэгтэй.

4.2. Иргэний хуулийн 355 дугаар зүйлд заасны дагуу энэхүү гэрээг цуцална.

### Тав. Бусад

5.1. Энэхүү гэрээ нь талууд харилцан тохиролцож гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

5.2. Талууд гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг нэг хувийг хадгална.

5.3. Талууд энэхүү гэрээнээс үүссэн аливаа маргааныг шүүхээр хуулийн хүрээнд шийдвэрлүүлнэ..

5.4. Талуудын энэхүү гэрээнд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлт нь бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурснаар энэхүү гэрээний адил хүчин төгөлдөр болно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| Захиалагчийг төлөөлж: | Гүйцэтгэгчийг төлөөлж: |
| --- | --- |
| Бүжгийн урлагийн сургуулийн | Эрэмгий жалаар ХХК-ны захирал |
| Нягтлан бодогч С.Далай | Ц.Мөнхбаатар |
| *Утас:* 70001996,70001995 | *Утас:* 99998801 |
| *Хаяг:*СБД, 11-р хороо 7-р хороолол-14180 | *Хаяг:* Баянзүрх дүүрэг 14-р хороо, консул-7, 195тоот |

"ЭРЭМГИЙ ЖАЛААР"ХХК

**Объектын нэр:**Улаанбаатар хот. СУИС-ийн хичээлийн 2-р байрны нэмэлт засварын ажлын төсөв

Төсөвт өртөг: 8 300 945 төгрөг

Төсөв зохиосон төсөвчин С.Баярням

Батлав Ц.Мөнхбаатар

УЛААНБААТАР ХОТ 2017 ОН